



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/72

Хөхбүрд

Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны
өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66,1, "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай "Засгийн газрын 2023 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр тогтоол, "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын эрчимжүүлэх тухай "Ерөнхий сайдын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, удирдан зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай А/460 дугаар захирамж, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалын хавсралтын 4.5.9 заалтуудыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, суманд зайлшгүй бэлтгэх өвс тэжээл аюулгүй нөөцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахад шаардагдах өвс тэжээлд шаардагдах зардлыг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (Д.Эрдэнэбулган)-д, Сан хариуцсан нягтлан бодогч (Э.Мөнх-Эрдэнэ) нарт зөвшөөрсүгэй.

3.Албан байгуулга аж ахуйн нэгж, иргэдийн халаалт, дулааны систем, шугам сүлжээг засаж сайжруулах болон төвлөрсөн халаалтын зуухны бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4.Малчдын нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгүүлэх, худалдан авах чиглэл өгч малчид өөрсдөө 1 хонин толгойд 3 кг-аас доошгүй өвс, тэжээл бэлтгэн цаг хүндэрсэн үед ашиглахаар нөөц бүрдүүлэх, хашаа, хороо,

642301145

худаг уст цэг болон хувийн бэлтгэлийг хангуулан ажиллахыг багийн Засаг дарга нарт хариуцуулсугай

5.Албан даалгаврын заалт тус бүрээр хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган, үйл ажиллагааны тайланг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг Хөдөө аж ахуй тасаг, Мал эмнэлгийн тасаг, багийн Засаг дарга нар, Аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.



Засаг даргын... Оны... дүгээр сарын...-ны өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЛБАН БАЙГУУЛЛАГА БАГУУДИЙН БЭЛТГЭВЭЛ
ЗОХИХ ӨВС ТЭЖЭЭЛИЙН ДООД ХЭМЖЭЭ (ТН)

№	Байгуулгын нэр	Өвс, тэжээл бэлтгэх төлөвлөгөө					
		Сумын нөөцөнд бэлтгэх, өвс, тэжээл		Малчны бэлтгэвэл зохих өвс, тэжээл			
		Өвс (тн)	Тэжээл (тн)	Өвс (тн)	Үйлдвэрийн тэжээл (тн)	Гар тэжээл (тн)	Давс, хужир шүү (тн)
1	2	3	4	5	6	7	8
1	Баян-Овоо сум	30	30	321	228,7	120	89
2	Иргэдийн Төлөөлөгчийн хурал	6	6				
3	Засаг даргын тамгын газар	6,5	6,5				
4	ЕБС-ийн сургууль	1	1				
5	Эрүүл мэндийн төв	1	1				
6	Цэцэрлэг	1	1				
7	Соёлын төв	0,5	0,5				
8	Мандалхайрхан 1 дүгээр баг	4	4	80,25	57,175	30	22,25
9	Уранхайрхан 2 дугаар баг	4	4	80,25	57,175	30	22,25
10	Асгамба дугаар баг	3	3	80,25	57,175	30	22,25
11	Мэргэн дүгээр баг	4	3	80,25	57,175	30	22,25

_____оОо_____

Засаг даргын.....оны.....дүгээр сарын.....-ны
өдрийн.....дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт



ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Орлогч дарга)

Гишүүд: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Д.Эрдэнэбулган (Санхүүгийн албаны дарга)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

_____оОо_____